

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТОДОТГОЛООР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮДЭД ОРСОН ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

ННФ-ын судлаач Б.Ундармаа

2025 оны төсвийн тодотгол

	2025 оны төсөв (2024.12.12)	2025 төсвийн тодотгол (2025.7.9)
Хөрөнгө оруулалын төслийн тоо	621	611
Хөрөнгө оруулалтын төслийн төсөвт өртөг	9.1 их наяд төгрөг	8.7 их наяд төгрөг
2025 онд олгох санхүүжилтийн дүн	3.1 их наяд төгрөг	2.9 их наяд төгрөг
Төсвийн ерөнхийлөн захирагчийн тоо	33	29

- УИХ-аас 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталсан Монгол улсын 2025 оны улсын төсөвт нүүрсний үнийг 105 ам.доллараар тооцож орлогыг төлөвлөсөн байсан ч дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнэ унаж, улсын төсвийн орлого тасарсан. Тиймээс 2025 оны төсөвт тодотгол хийх хуулийн төслийг Засгийн газраас 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлж, Улсын Их Хурал 7 дугаар сарын 9-ний өдөр баталсан юм.
- 2024 оны 12 дугаар сард батлагдсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад 33 төсвийн ерөнхийлөн захирагчийн 9.1 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалтын 621 төсөл туссан бол 2025 оны 7 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан 2025 оны төсвийн тодотголд 29 төсвийн ерөнхийлөн захирагчийн 8.7 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий нийт 611 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд 2.9 их наяд төгрөгийн санхүүжилт 2025 онд олгохоор туссан.

2025 оны төсвийн тодотголоор хөрөнгө оруулалтын төслүүдэд орсон өөрчлөлт (төслийн тоо, төрлөөр)

№	Төслийн төрөл	УИХ-аас баталсан огноо	Шинэ төслийн тоо	Шилжих төслийн тоо
1	Барилга байгууламж	2024.12.12-нд баталсан	42	492
		2025.7.9-ний төсвийн тодотголоор баталсан	41	486
2	Их засвар	2024.12.12-нд баталсан	18	6
		2025.7.9-ний төсвийн тодотгол	17	6
3	Тоног төхөөрөмж	2024.12.12-нд баталсан	43	12
		2025.7.9-ний төсвийн тодотгол	42	12
4	ТЭЗҮ	2024.12.12-нд баталсан	7	1
		2025.7.9-ний төсвийн тодотгол	6	1

- 2025 оны төсвийн тодотголоор шилжих төслийн хувьд зөвхөн барилга байгууламжийн ангиллын төслийн тоо хасагдаж, бусад төслийн төрөлд өөрчлөлт ороогүй байна. Барилга байгууламжийн шилжих төсөл нийт төслийн ихэнх хувийг (96.3%) бүрдүүлсэн хэвээр байна.
- 2025 онд шинээр эхлэх төслийн хувьд бүх төсөл, арга хэмжээний төрөл тус бүр нэг, нэг төслөөр буурсан үзүүлэлттэй байна.
- 2025 оны төсвийн тодотголоор өмнөх онд батлагдсан хөрөнгө оруулалтын төслүүдээс 17-г хасаж, 7 цоо шинэ төслийг нэмэн нийт 209.1 тэрбум төгрөгийн хэмнэлтийг хийхээр баталжээ.

2025 оны төсвийн тодотголоор шинээр нэмэгдсэн хөрөнгө оруулалтын 7 төслийн мэдээлэл (тэрбум төгрөг)

Төслийн нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг 2025 онд	2025 онд санхүүжих дүн
Их засвар /УБ, ЧД/	2025	2025	2.3	2.3
Дулааны III цахилгаан станцын өргөтгөл хэсгийн дээвэр болон байрны засвар /УБ, ХУД/	2025	2025	7	7
Дулааны III цахилгаан станцын дулаанжуулалтын тоноглолын өргөтгөл, шинэчлэл /УБ, ХУД/	2025	2025	8.5	8.5
Дулааны III цахилгаан станцын турбингенератор №7 шинээр суурилуулах /УБ, ХУД/	2025	2026	30	5
Дулааны III цахилгаан станцын 50 МВт-ын турбингенератор №9 шинээр суурилуулах /УБ, ХУД/	2025	2026	60	15
НҮБ-ын "Цөлжилттэй тэмцэх тухай" суурь конвенцын талуудын 17 дугаар бага хурлын байгууламж /УБ/	2025	2025	8.1	8.1
Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум/ төслийн нэмэлт санхүүжилт	2025	2025	3.7	3.7

- Нийт 119.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий тоног төхөөрөмжийн 3, их засварын 2, барилга байгууламжийн 2 төслийг тус тус нэмснээр 2025 онд 49.7 тэрбум төгрөгийн санхүүжих үнийн дүнтэй төслүүдийг төсвийн тодотголд нэмж тусгасан байна.
- Шинээр нэмэгдсэн төслүүдээс хамгийн өндөр төсөвт өртөгтэй (60 тэрбум төгрөг) төсөл нь Эрчих хүчний сайдын багцад хамаарах УБ хотод хэрэгжих *Дулааны III цахилгаан станцын 50 МВт-ын турбингенератор №9 шинээр суурилуулах* төсөл байна. Харин хамгийн бага төсөвт өртөгтэй (2.3 тэрбум төгрөг) төсөл нь Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд эдийн засгийн хөгжлийн сайдын багцад хамаарах Чингэлтэй дүүрэгт хэрэгжих их засварын төсөл байна.
- 2025 онд Дулааны III цахилгаан станц дээр хэрэгжих тоног төхөөрөмжийн 3 төсөл нь өмнөх оны тоног төхөөрөмжийн төслүүдтэй харьцуулахад ерөнхийдөө өндөр төсөвт өртөгтэй байна.

Энэхүү нэмэгдэж буй 7 төслөөс 5 төслийн санхүүжилтийг 2025 онд 100% олгохоор төлөвлөжээ.

2025 төсвийн тодотголоор хасагдсан 17 төсөл: №1-8 (тэрбум төгрөг)

Төслийн нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг 2025 онд	2025 онд санхүүж их дүн
Таравчамбуулин хийдийн авга дуганыг сэргээн засварлах /Архангай, Батцэнгэл сум/	2025	2026	1.8	0.4
Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн их засвар /УБ, СБД/	2025	2025	1.3	1.3
Хяналт үнэлгээний Үндэсний хорооны их засвар /УБ/	2025	2025	2.4	2.4
ТЭЗҮ-1 шинэ төсөл				
ХААИС-ийн Мал аж ахуй, био технологийн сургуулийг Дархан, Сэлэнгийн бүс рүү нүүлгэхтэй холбоотой зураг төсөв /Төвийн бүс/	2025	2025	0.8	0.8

- 2025 оны төсвийн тодотголоор нийт **129.1 тэрбум** төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл хасагдсан бөгөөд эдгээрийн 2025 онд санхүүжих нийт дүн нь **76.9 тэрбум** төгрөг байжээ.
- Эдгээр төслийн байршлын хувьд 10 нь хөдөө орон нутагт, 7 нь Улаанбаатар хотод хэрэгжих төслүүд байна.

Төслийн нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг 2025 онд	2025 онд санхүүжих дүн
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/	2025	2025	19.2	1962
Сэлгэн ажиллах дата төвийн нөөцийн тоног төхөөрөмж /УБ, СХД/	2025	2025	9.5	9.5
Хил хамгаалах ерөнхий газарт хэрэгжүүлэх “BPF-24mm” дрон бүтээх, турших, үйлдвэрлэж албанд нэвтрүүлэх	2025	2025	1.2	1.2
Үндэсний аудитын газрын тоног төхөөрөмж /УБ, ЧД/	2025	2025	1.1	1.1

2025 төсвийн тодотголоор хасагдсан 17 төсөл: №9-17 (тэрбум төгрөг)

Төслийн нэр	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг 2025 онд	2025 онд санхүүжих дүн
Цэцэрлэгийн барилгын өргөтгөл, 200 ор /Завхан, Улиастай сум, 3 дугаар цэцэрлэг/	2025	2027	4.5	1
Сургуулийн барилга, 640 суудал /УБ, БЗД, 34-р хороо/	2024	2025	15.7	11.7
Сургуулийн барилгын өргөтгөл /Сэлэнгэ, Мандал сум, 3 дугаар сургууль/	2019	2025	3.8	1
Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Баяндэлгэр сум/	2019	2026	2.1	0.7
Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сүхбаатар, Эрдэнэцагаан сум/	2018	2026	2.1	0.5
Хэрээтийн давааны хэсгийн 35.5 км хайрган хучилттай авто зам, Түнэл сумаас Чандмань - Өндөр сум чиглэлийн авто замын Бийжийн даваа, Бор бургасын давааны хэсгийн 9 км хайрган хучилттай авто зам /Хойд бүс/	2025	2026	15.1	6
Улаанбаатар-Шар хөтөл-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай авто замын эхлэл, 92.13 км /Орхон, Дархан-Уул, Төв/	2024	2025	16.1	8
Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн ариутгах татуургын шугам сүлжээ /Төв, Сэргэлэн сум/	2025	2027	21.9	6.5
Хавдар судлалын Үндэсний төв-II барилга /Улаанбаатар/	2024	2025	10	5


- 2025 оны төсвийн тодотголоор хасагдсан хөрөнгө оруулалтын төслүүдийн дийлэнх хувийг барилга байгууламжийн төсөл (9) эзэлж байна. Эдгээрийн 8 нь шилжих, 1 нь шинэ төсөл байна. Түүнчлэн их засварын 3, тоног төхөөрөмжийн 4, ТЭЗҮ-ийн 1 төслийг тус тус хассан байна.
- Төсвийн тодотголоор хасагдсан төслүүдээс хамгийн эрт эхэлсэн төсөл нь 2018, 2019 онд Сүхбаатар аймагт эхлүүлсэн 200 ортой цэцэрлэгийн 2 барилгын төсөл, 2019 онд Сэлэнгэ аймагт эхлүүлсэн сургуулийн барилгын төсөл байгаа нь анхаарал татаж байна. Эдгээр төсөлд 2025 онд харьцангуй бага санхүүжилтийг өгч дуусгахаар төсөвт туссан байсныг УИХ хассан нь учир дутагдалтай байна.

2025 оны төсвийн тодотголоор хасагдсан төслүүдийн тоо, Төсвийн ерөнхийлөн захирагчаар (тэрбум төгрөг)

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	Төслийн тоо	Төсөвт өртөг 2025 онд	2025 онд санхүүжих дүн
1	Боловсролын сайд	6	29.1	15.8
2	Зам тээврийн сайд	2	31.2	14.1
3	Монгол Улсын Ерөнхий Аудитор	1	1.1	1.1
4	Монгол Улсын сайд, хяналт үнэлгээний үндэсний хорооны дарга	1	2.4	2.4
5	Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын сайд	2	21	19.6
6	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	1	21.9	6.5
7	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	2	10.7	10.7
8	Эрүүл мэндийн сайд	2	11.3	6.3
Нийт дүн		17	129.1	76.9

- Төсвийн тодотголоор Боловсролын сайдын багцад байсан 6 төслийг хасчээ. Эдгээрээс 4 нь шилжих, 2 нь шинэ хөрөнгө оруулалт байсан бөгөөд 5 төсөл нь сургууль, цэцэрлэгийн барилга байгууламж, 1 төсөл нь ТЭЗҮ эдийн засгийн ангилалд хамрагдаж байна.
- Хүснэгтээс харахад Эрүүл мэндийн сайдын багцад буй 2 төсөл нь бусад төсөлтэй харьцуулахад бага үнийн дүнтэй байгаа бөгөөд Хавдар судлалын Үндэсний төв-II /Улаанбаатар/ барилгын төсөл 2024 онд эхлээд явж байхад энэ оны төсвийн хөрөнгө оруулалтаас хасаж 2025 онд санхүүжилт олгохгүй байхаар туссан нь анхаарал татаж байна. Монгол Улсын эрүүл мэндийн салбарын тогтолцоо маш хангалтгүйн дээр уг сайдын багцын төслүүдийг хасах нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хангамжид сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

2025 оны төсвөөс санхүүжих 2011-2020 онуудад эхэлсэн хөрөнгө оруулалтын шилжих төслүүдийн тоо



- Төсвийн тодотголоор өмнөх онуудаас шилжиж ирсэн төслүүдээс 2025 онд санхүүжилт олгох хамгийн эрт эхэлсэн төслүүдийг дурдвал:
 - 2011 онд УБ, СХД-т эхэлсэн Барилга байгууламжийн хийц бүтээцийн газар хөдлөл, сорил шинжилгээний төв лабораторийн барилгын төсөл,
 - 2012 онд УБ, БЗД, 13 дугаар хороонд эхэлсэн Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спорт танхимын барилгын төсөл,
 - 2013 онд УБ хотод эхэлсэн Гэр хорооллын дахин төлөвлөлт, инженерийн дэд бүтэц, Дүүргүүдийн шүүхийн нэгдсэн байр, Дүүргүүдийн прокурорын нэгдсэн байрын төсөл тус тус байна.

Өмнөх онуудаас шилжиж ирсэн, он удаан жил үргэлжиж буй төслүүд нь бүгд барилга байгууламжийн төрөлд хамаарагдаж байгаа бөгөөд 2011 онд эхэлсэн лабораторийн барилгын төсөл 14 жилийн хугацаанд баригдаж дуусаагүй байгаа нь анхаарал татаж байна. Графикаас харахад жил ирэх тусам шилжих төслийн тоо өссөн харагдаж байна. Дээрх шилжих 2020 онд эхэлсэн 17 төслийн 1 төсөл, арга хэмжээ нь их засварын төсөл, 16 нь мөн адил барилга байгууламжийн ангилалд багтсан байна. Иймд барилга байгууламжийн олон төсөл он дамнан дуусахгүй олон жил үргэлжилж байгааг анхаарах нь зүйтэй.

Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголд туссан төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийг Төсвийн ерөнхийлөн захирагчаар нь харьцуулсан байдал: №1-13

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	2024.12.12 өдөр УИХ баталсан	2025.7.9 өдөр УИХ баталсан	Өөрчлөлт (тэрбум төгрөг)
		төслүүдийн санхүүжих дүн (тэрбум төгрөг)		
1	Эрүүл мэндийн сайд	193	145.9	-47.1
2	Зам, тээврийн сайд	951.2	918	-33.1
3	Боловсролын сайдын багц	472.6	446.3	-26.3
4	Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын сайд	145.2	125.5	-19.6
5	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	354	334.7	-19.3
6	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	35.7	23.3	-12.3
7	Монгол Улсын тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	51.4	39.3	-12
8	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	80.8	69.5	-11.3
9	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	62.9	52.7	-10.2
10	Батлан хамгаалахын сайд	75.4	65.8	-9.6
11	Хууль зүй, дотоод хэргийн сайд	108.5	104.7	-3.8
12	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	52.2	48.7	-3.5
13	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	58.5	56.2	-2.2

- 2025 оны төсвийн тодотголоор хэмнэж буй мөнгөн дүнгээрээ Эрүүл мэндийн сайдын багцад хамаарах төслүүд 47.1 тэрбум төгрөгөөр тэргүүлж байна. Дараа нь Зам, тээврийн сайдын багц 33.1 тэрбум төгрөг, Боловсролын сайдын багц 26.3 тэрбум төгрөг, Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын сайдын багц 19.6 тэрбум төгрөг, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багц 19.6 тэрбум төгрөгөөр тус тус хэмнэлт хийсэн байна.
- Хэрэгжүүлэх төслийн тоогоор Боловсролын сайдын багц (184), Зам тээврийн сайдын багц (95), Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (56), Соёл, спорт, аялал, жуулчлал, залуучуудын сайд (48) болон Эрчим хүчний сайдын багц (42)-ууд тэргүүлж байна. 2025 онд санхүүжих мөнгөн дүнгээрээ Зам тээврийн сайд (918 тэрбум төгрөг), Боловсролын сайд (446.3 тэрбум төгрөг), Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд (334.7 тэрбум төгрөг), Эрчим хүчний сайд (229.4 тэрбум төгрөг), болон Эрүүл мэндийн сайд (145.9 тэрбум төгрөг) дээгүүр байр эзэлж байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголд туссан төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийг Төсвийн ерөнхийлөн захирагчаар нь харьцуулсан байдал: №14-29

№	Төсвийн ерөнхийлөн захирагч	2024.12.12 өдөр УИХ баталсан	2025.7.9 өдөр УИХ баталсан	Өөрчлөлт (тэрбум төгрөг)
		төслүүдийн санхүүжих дүн (тэрбум төгрөг)		
14	Гадаад харилцааны сайд	11.2	9.5	-1.6
15	Монгол Улсын сайд, ЗГХЭГД	24.2	23.1	-1
16	Монгол Улсын шадар сайд	42.4	41.5	-0.9
17	Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч	4.6	4	-0.5
18	ХЭҮК-ын дарга	2.7	2.2	-0.4
19	Монгол Улсын Ерөнхийлөгч	1	0.6	-0.3
20	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	0.984	0.7	-0.2
21	ҮСХ-ны дарга	2	1.8	-0.1
22	Монгол Улсын Ерөнхий сайд	1.5	1.4	-0.1
23	Авлигатай тэмцэх газар	2.3	2.2	-0.07
24	Улсын ерөнхий прокурор	29.8	29.8	-0.01
25	СЗХ-ны дарга	0.25	0.24	-0.01
26	Монгол Улсын Их хурлын дарга	8.5	8.5	0
27	Шүүхийн сахилгын хорооны дарга	0.3	0.3	0
28	Сангийн сайд	126.2	127.7	+1.4
29	Эрчим хүчний сайд	196.1	229.4	+33.2

- 2024 оны 12 дугаар сард батлагдсан 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл 33 ТЕЗ нарт хамаарагдаж байсан бол 2025 оны төсвийн тодотголоор 29 ТЕЗ болж буурчээ. Дөрвөн ТЕЗ тодотголоор хасагдаж батлагдсан боловч үүнээс хоёр ТЕЗ-ийн хөрөнгө оруулалтын төслүүдийг Сангийн сайд болон Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын багц руу санхүүжих дүнг бууруулж тус тус шилжүүлсэн. Харин Монгол Улсын ерөнхий аудитор болон Монгол Улсын сайд, хяналт үнэлгээний хорооны даргын багцад хамаарах төслүүдийг төсвийн тодотголоор хассан байна.
- Төсвийн тодотголоор 2025 онд санхүүжих дүн нь нэмэгдэж батлагдсан хоёр ТЕЗ-ийн тоонд Сангийн сайд болон Эрчим хүчний сайд нар байна. Сангийн сайдын багц 1.4 тэрбум төгрөгөөр, Эрчим хүчний сайдын багц 33.2 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан. Энэ нь Эрчим хүчний сайдын багцад төсвийн тодотголоор 105.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий Дулааны гуравдугаар цахилгаан станцын 4 шинэ төсөл, Сангийн сайдын багцад өнгөрсөн онд батлагдсан Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын багцад туссан 3 төсөл, арга хэмжээг нэмсэнтэй холбоотой юм.

2025 онд санхүүжилт олгогдохгүй 22 төслийн жагсаалт, тэрбум төгрөг

Төслийн нэр	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг анхны	Төсөвт өртөг сүүлийн 2025
Яслийн барилга буулгаж, шинээр барих, 120 ор /Хэнтий, Хэрлэн сум, 4 дүгээр баг/	2024	2026	3.2	3.1
Насан туршийн боловсролын төвийн барилга /УБ, БЗД, 21, 27 дугаар хороо/	2022	2025	2.5	3.1
Сургуулийн барилга, 640 суудал, спорт заал /Хөвсгөл, Жаргалант сум, 5 дугаар баг/	2022	2025	10.1	15.1
Сургуулийн барилга, урлаг заал /Дорнод, Баяндун сум, 1 дүгээр баг/	2022	2025	3.3	4.5
Сургуулийн хичээлийн байрны барилга, 160 суудал /Говь-Алтай, Дэлгэр сум, Гуулин тосгон/	2022	2025	2.8	3.1
Цэцэрлэгийн барилга худалдан авах, 300 ор /УБ, БГД, 24 дүгээр хороо/	2022	2026	4.8	4.8
Цэцэрлэгийн барилга, 150 ор /Говьсүмбэр, Шивээговь сум, 1 дүгээр баг/	2022	2025	2.2	2.7
Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 4 дүгээр баг/	2022	2025	4.1	6.3
Цэцэрлэгийн барилга, 50 ор /Улаанбаатар, Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо, Өргөө цэцэрлэг/	2022	2025	2	2.3
Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 200 ор /УБ, БГД, 198 дугаар цэцэрлэг/	2022	2025	4.4	4.9
Сургуулийн барилга, 960 суудал /Дундговь, Сайнцагаан сум, Говийн ирээдүй цогцолбор/	2021	2025	5.4	14.2
Сургуулийн барилга, урлаг заал, 200 суудал /Хэнтий, Мөрөн сум/	2021	2025	2.5	5

Төслийн нэр	Эхлэх он	Дуусах он	Төсөвт өртөг анхны	Төсөвт өртөг сүүлийн 2025
Цэцэрлэгийн барилга, 150 ор /Архангай, Төвшрүүлэх сум/	2021	2025	1.4	2.4
Цэцэрлэгийн барилга, 200 ор /Хэнтий, Бор-Өндөр сум/	2021	2025	2.2	5.5
Сургуулийн спорт заалны барилга /Хэнтий, Биндэр сум/	2020	2025	0.5	1.2
Сургуулийн барилга, 320 суудал /Өмнөговь, Цогт-Овоо сум/	2019	2025	3.5	4.6
Сургуулийн барилга, 720 суудал /УБ, СБД, 12 дугаар хороо/	2019	2025	6	9.6
Сургуулийн барилгын өргөтгөл, 640 суудал /УБ, ЧД, 5-р сургууль/	2018	2025	4	6.8
Сумын төвийн авто замын шинэчлэл, 2.15 км /Дорноговь, Замын-Үүд сум/	2024	2025	4.7	4.7
Улсын чанартай авто замтай холбох хатуу хучилттай авто замын эхлэл /Сэлэнгэ, Хушаат сум/	2024	2025	2.4	2.4
Хатуу хучилттай авто зам, 4.1 км /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/	2024	2025	6.1	5.9
Хөлийн гол-2, 3, Хонхор нуур-2 орчмын цахилгаангүй айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчээр хангах /УБ, БЗД, 11-р хороо/	2024	2026	0.7	0.6

- 2025 онд санхүүжилт олгогдохгүй буюу санхүүжих дүн “0” гэж төсвийн тодотголд батлагдсан 22 хөрөнгө оруулалтын төсөл байна. Дээрх 22 төсөл нь бүгд барилга байгууламжийн ангилалд шилжих хөрөнгийн шинж чанартай төслүүд юм. Үүнээс Боловсролын сайдын багцын 18, Зам тээврийн сайдын багцын 3, Эрчих хүчний сайдын багцын 1 төсөл тус тус орсон байна. Эдгээр санхүүжилт олгогдохгүй төслүүдийг төсөвт өртгийн өөрчлөлтөөр нь ангилбал:

- Анхны болон сүүлийн төсөвт өртөг нь өөрчлөгдөөгүй 2 төсөл, арга хэмжээ
- Анхны төсөвт өртөг нь сүүлийн төсөвт өртгөөсөө буурсан 4 төсөл, арга хэмжээ
- Сүүлийн төсөвт өртөг нь анхны төсөвт өртгөөсөө нэмэгдсэн 16 төсөл, арга хэмжээ тус тус байна.

Хүснэгтээс харахад хамгийн эрт буюу 2018, 2019 онд эхэлсэн барилга байгууламжийн төслүүд өнөөг хүртэл дуусаагүй төдийгүй дуусах хугацаа нь ихэнх нь 2025 он гэж төлөвлөсөн байтал 2025 онд санхүүжилт олгохгүй байгаа нь төслийн явцыг удаашруулж, Засгийн газар төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж, төлөвлөж байгааг харуулж байна.

Тойм дүгнэлт

- 2025 оны 7 дугаар сарын 9-нд батлагдсан Монгол Улсын 2025 оны төсвийн тодотголоор улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад шинээр 7 төсөл нэмж, 17 төсөл хасаж, 2024 онд батлагдсан 621 төслийн тоог 611 болгон бууруулж 209.1 тэрбум төгрөгийн хэмнэлт хийхээр туссан. Тодотголоор 611 төслөөс 2025 онд санхүүжих дүн нэмэгдсэн 55, санхүүжих дүн буурсан 102, дүнд өөрчлөлт ороогүй 425 төсөл, арга хэмжээ байна.
- Төсвийн тодотголоос харахад хасаж эсвэл хойшлуулж болохуйц барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн төслүүд нэлээдгүй байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл санхүүжилтийн дүнгээр тооцвол 2025 оны 6 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар 12 хувьтай байгаа нь туйлын хангалтгүй үзүүлэлт юм. *(Эх сурвалж: Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс өгсөн дүгнэгт тайлан, 2025 оны 6 дугаар сарын 26-ны өдөр)*
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төслүүдийн ач холбогдлын эрэмбэлтийг дахин хийх, төсөвт өртгийн тооцооллыг дахин хянах, онцын шаардлагагүй төслүүдийг жагсаалтаас хасах талаар тодорхой ажлууд хийгдсэн эсэх нь төсвийн тодотголд тодорхойгүй байна. Улсын төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах нь манай хөгжиж буй орны нийгэм, эдийн засгийн хөгжилд маш чухал юм.